



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/250

Мандлаговь

Түгээмэл тархацтай ашигт малтмалын  
ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох тухай

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Улаан” нэртэй 104.7 га талбайд XV-48000008 (003/Ду) тоот түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Монгоулд” ХХК-д түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг доорх солбицлын дагуу 15 жилийн хугацаагаар олгосугай.

Д/д	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	Град	мин	Сек
1	108	11	6.59	45	56	51.62
2	108	10	21.59	45	56	51.62
3	108	10	21.59	45	57	26.62
4	108	11	6.59	45	57	26.62

2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг аж ахуйн нэгжид хуулийн дагуу олгон, энэ тухай холбогдох төрийн байгууллагуудад мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг, Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлүүдэд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг болон байгаль орчныг хамгаалах үүргээ хэрэгжүүлж ажиллахыг “Монгоулд” ХХК-ний захирал (Г.Болд-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210061